



## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Ашигт малтмалын тухай хууль нь Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг гол хууль болохын хувьд салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, газар, өмч, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулсан, бусад хуультай нийцсэн, давхардал, хийдэл, зөрчилгүй байх шаардлагатай байдаг.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 11 бүлэг 59 зүйлийн хэсэг, заалтууд ямар нэгэн байдлаар хөндөгдсөн байна. Тодруулбал, нэмэлт, өөрчлөлт оруулсан 5 зүйл 95 хэсэг, 101 заалт, шинээр нэмсэн 48 хэсэг, 54 заалт, өөрчлөн найруулсан 22 хэсэг, 28 заалт, хүчингүй болсонд тооцсон 10 зүйл, 3 хэсэг 13 заалт буюу нийт 300 орчим нэмэлт, өөрчлөлт оржээ. Ингэснээр хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн агуулга, зорилго алдагдаж, анх батлагдсан үзэл баримтлалдаа нийцэхгүй болсноор салбарт хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, хөрөнгө оруулалтыг бууруулах эрсдэлд хөтөлж байна.

Хууль хэрэгжсэн хугацаанд Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт нь хуулийн цогц шинэчлэлийг шаардаж байна.

Эдгээрт үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 8 дугаар зүйлийн 8.1.1-д зааснаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний дагуу<sup>2</sup> Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагыг тодорхойлж байна.

<sup>1</sup> Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25

<sup>2</sup> Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. (2021)

## 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1.-т Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төслүүдийн “Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэсэгт “Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээр үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Мөн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.6-д “Уул уурхайн салбарын институтийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, тусгай зөвшөөрөл олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно” гэж, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2-т “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ” гэж, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын 131-д “Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ, Шинэ сэргэлтийн бодлогод хэтийн төлөв бүхий талбайд геологичайгуулын ажил гүйцэтгэнэ гэж тус тус тусгасан.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/67 дугаар тушаалаар “Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах” үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан Ашигт малтмалын тухай болон эрдэс баялгийн салбарт мөрдөж байгаа 10 хуульд дүн шинжилгээ хийж, нийт 267 давхардал, 150

зөрчил, 150 хийдэл байгааг тогтоосон нь тус салбарт дахь эрх зүйн орчны гажуудлыг залруулах шаардлагыг харуулж байна.

## **1.2. Практик үндэслэл, шаардлага**

Монгол улсын уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж, салбарын үйл ажиллагаа эрчимжихийн хирээр түүнийг даган бий болж буй шинэ тутам харилцаануудыг 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахад хүндрэл учирч, тус хуулийг боловсронгуй болгох, өөрчлөх замаар шийдвэрлэвэл зохих олон асуудал үүсэж байна. Тухайлбал:

### 1.2.1.Хуулийн зохицуулах зүйлийн хүрээг хариуцлагатай уул уурхай руу чиглүүлэн өргөтгөх талаар:

Ашигт малтмалын тухай хуулийн агуулга нь нөхөн сэргээгдэхгүй баялгийг нийт улс орон, хүн ардын хэтийн сайн сайхны төлөө урт хугацааны бодлого зохицуулалттайгаар ашиглах зарчмыг дэмжихэд чиглэх учиртай.

Энэ хүрээнд төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийг зохисгүй ашиглалтаас хамгаалах, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нарийвчлах, салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, олон нийтийн эрх ашигт үзүүлэх нөлөөллийн асуудлыг тэргүүн ээлжид авч үзэн зохицуулах, салбарт оролцогчдын ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах байдлаар хариуцлагатай уул уурхайг дэмжих чиглэлд хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

Улсын Их хурлаас 2006 онд баталсан Ашигт малтмалын тухай хуулийн зорилго нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах агуулгатай бол шинээр боловсруулах хуулийн хүрээнд дээрхээс гадна хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар өргөжүүлэх нь зүйтэй байна.

Тухайлбал, ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, төрийн хяналтад байх, талуудын оролцоо тэгш, шударга, ил тод, харилцан үр ашигтай, хариуцлагатай байх, сорчлон ашиглахгүй байх зэрэг зарчмуудыг хуульчилж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах хүний нөөцийн болон баримт бичгийн шаардлагуудыг нарийвчилж, уурхай, үйлдвэрийн хаалтын зохицуулалтыг шинээр нэмж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэгт хариуцлагатай уул уурхайн зарчимд суурилсан үүргүүдийг тодорхой тусгаж, технологийн аудит буюу зохиогчийн хяналтын тухай ойлголтыг хуульчилна.

### 1.2.2.Чухал ашигт малтмалын талаар:

Улс орон бүр өөрийн үндэсний аюулгүй байдалд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд шууд хамаарал бүхий ашигт малтмалыг “Чухал” бүлэгт хамааруулан зарлаж тухайн төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэх чиглэлд тусгайлан бодлого гарган хэрэгжүүлж байна. Манай улс геологийн тогтцын хувьд газрын ховор элемент, батарейн түүхий эдийн хэтийн төлөв ихтэй.

Иймд Монгол Улсын хувьд чухалд тооцогдох ашигт малтмалын төрлүүдийг тодорхойлж, түүнтэй холбоотой бодлогыг улсын хөгжлийн бодлогуудад тусгайлан тусгаж хэрэгжүүлэх, энгийн ашигт малтмалаас онцлог зохицуулалт, үйл ажиллагааны горимтой байх нөхцөлүүдийг хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

Чухал ашигт малтмалтай холбоотой зохицуулалт нь стратегийн ач холбогдолтой ордын зохицуулалтаас зарчмын ялгаатай байна. Тодруулбал, хуулиар хориглосон, хязгаарласан газарт чухал ашигт малтмалыг хайх, ашиглах тохиолдолд улсын тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээний газраас гаргах асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд шийдвэрлэх, уг шийдвэрийг үндэслэн хориглосон, хязгаарласан талбайд тусгай горимоор чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрхэлж болох зохицуулалтыг хуульд тусгана.

### 1.2.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын талаар:

Хайгуулын үйл ажиллагаа нь улс орныг урт хугацаанд эрдэс баялгийн найдвартай нөөцөөр хангаж, уул уурхайн салбарын үйл ажиллагааг тогтвортой байлгах, ашигт малтмалын сан хөмрөгийг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг тасралтгүй, найдвартай хангах замаар улс орны эдийн засгийн суурь үндсийг бэхжүүлэн, тогтвортой хөгжлийг тэтгэж өгөх үүрэгтэй.

Ашигт малтмалын тухайн хуулийн шинэчилсэн найруулга 2006 онд батлагдан 2007 онд хэрэгжиж эхэлснээс хойш хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 4111 /2008/ байсан нь 870 /2023/ болон буурч түүний нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалт оргил үедээ 335 тэрбум төгрөгт хүрч байсан нь өнгөрсөн онд 104 тэрбум төгрөг болж 3 дахин буурсан байна. Мөн 1997 оноос хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож эхэлсэн үе болон өнөөдөр хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн харилцан хамаарлыг судлахад 50 хайгуулын тусгай зөвшөөрөл тутмын 1 нь олборлолтод шилжиж байна. Иймд хайгуулын ажлыг эрчимжүүлснээр ашигт малтмалын шинэ орд газрыг нээх боломжийг өсгөх ба улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа нь тэгш, шударга, нээлттэй байх зарчмыг хангаж байгаа хэдий ч зарлагдаж буй бүх талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэрэг тохиолдлын эзлэх хувь 40-46%-д хүрч байгаа нь сонгон шалгаруулалт зарлаж буй талбайнуудад хэтийн төлөв бүхий талбай бага буюу хөрөнгө оруулагчдын сонирхож буй талбай зарлагдахгүй байгааг илтгэж байна. Энэ нь 2018 онд сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болох талбайг баталснаас хойш тухайн талбайд ашигт малтмалын хэтийн төлөв бүхий сонголт үлдээгүйтэй холбоотой. Иймд тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

### 1.2.4.Ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагааны талаар:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн “ашигт малтмал ашиглах” гэдэг тодорхойлолтоос жишээ татахад “хүдэр олборлох, олборлосон хүдрээ цэвэршүүлээд алт гаргаж түүгээрээ эцсийн бүтээгдэхүүн хийх, зах зээлд борлуулах” хүртэл үйл ажиллагаа нь ашиглалтын гэх нэг тусгай зөвшөөрлөөр дамжин хэрэгжихээр зохицуулалттай. Нэг талаас эдгээр үйл ажиллагаанууд нь нэг этгээдийн цогц үйл ажиллагаагаар хэрэгжиж болохоор харагдавч нөгөө талаар бүгд тус тусдаа бие даасан үйл ажиллагаа бөгөөд тус бүрд нь өөр өөр субъект хэрэгжүүлэх боломжтой.

Олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд тэр бүр боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэггүйгээс өөрөө олборлолт явуулдаггүй зөвхөн олборлосон ашигт малтмалыг олборлогчдоос худалдан авч ашигт агуулгыг нь нэмэгдүүлэх, баяжуулах, хагас боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулдаг компаниуд олноороо бий болж байна.

Хуулийн шинэчлэлээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хэр нь ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг салбарын эрх зүйн зохицуулалтад бүрэн хамруулна. Ингэснээр, тусгай зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаарч ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, экспортолсон этгээд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байхаар Ашигт малтмалын тухай хуульд 2019 онд оруулсан өөрчлөлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт цогц байдлаар бүрдэнэ. Ялангуяа, гарал үүсэлгүй хүдрийг хяналтгүйгээр худалдан авч хууль бус олборлолтыг өөшүүлэх, татвараас зайлсхийхээс гадна баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил далд байдлаар хяналтгүй ашиглах, хаягдлын далан, аж ахуйн горим алдагдах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх, хаалтын болон явцын мониторинг хийгдэхгүй байх зэрэг олон сөрөг үр дагавар үүсгэж буй гажуудлыг арилгана.

Түүнчлэн хатуу болон шингэн хэлбэрийн хаягдлын далан, ядуу агуулгатай хүдрийн овоолго зэрэг үүсмэл ордыг ашиглах эрх зүйн зохицуулалт оновчгүйгээс ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны үүрэг хариуцлага болон техник, технологийн шаардлагуудаас зайлсхийх зорилгоор үүсмэл ордыг дахин ашиглалгүй бусдад худалдах, түрээслэх, өөр аж ахуйн нэгжийн нэр дээр баяжуулалт хийх замаар татвар, хураамж төлөхгүй байх арга замыг эрэлхийлэх тохиолдлууд гарсаар байгаа тул ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн үүсмэл ордыг өөрөө ашиглах хөшүүргийн механизмыг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

Дээрхээс үндэслэн “ашигт малтмал баяжуулах” тусгай зөвшөөрлийн тухай зохицуулалтыг хуульд шинээр тусгаж, ингэхдээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

#### 1.2.5. Ашигт малтмалын эрлийн үйл ажиллагааг хувийн хөрөнгөөр хийх талаар:

Геологи, уул уурхайн салбарын олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхэд ашиглалтын өмнөх шат буюу эрэл, хайгуулын судалгааны ажлын цар хүрээг тэлэх зайлшгүй шаардлагатай байна. Одоогийн хууль тогтоомжийн хүрээнд геологийн суурь судалгаа, эрлийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх зохицуулалттай. Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайг илрүүлэх эрлийн ажлыг явуулах улсын төсвийн хөрөнгө төдийлөн хангалтгүй буюу төсвийн боломжоос хамаарч судалгааны цар хүрээ хязгаарлагдаж байгаа тул хувийн хөрөнгөөр эрэл хийх боломжийг нээж өгөх нь салбарын хөгжилд түлхэц болох юм.

Иймд хуулиар хориглосноос бусад газарт ашигт малтмалын эрлийн үйл ажиллагаа явуулахад хувийн хэвшлийн оролцоог нээлттэй болгож, холбогдох төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулах замаар, тусгай зөвшөөрөл

шаардахгүйгээр, өөрийнх нь зардлаар эрлийн ажлыг гүйцэтгүүлж болох боломжийг бий болгох шаардлагатай байна.

Ингэхдээ улсын болон хувийн аль ч хөрөнгөөр хийсэн эрлийн ажлын үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөв тогтоогдвол уг талбайг хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайд хамруулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгохоор зохицуулна.

Харин хуулиар ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа явуулахыг хориглосон болон тусгай горимоор явуулах талбайд зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр эрлийн ажил хийх, үр дүнд нь хэтийн төлөв тогтоогдвол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулахаар хязгаарлах нь зүйтэй байна.

#### 1.2.6. Ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглох, хязгаарлах талбайн талаар:

2023 оны эхний байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 75.4 хувьд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй, хориглогдсон байдалтай байна. Эдгээр газар нутгийг ангилан авч үзвэл:

- Улсын тусгай хэрэгцээний болон хамгаалалттай газар нутаг болон цаашид энэ ангилалд хамруулахаар төлөвлөж буй газар нийлээд 21.7%
- Орон нутгийн тусгай хэрэгцээний газар 21.5%
- Ойн сан бүхий газрын хил зааг 11.7%
- Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг 9.1%
- Засгийн газраас нөөцөд авсан талбай 4.3%
- Усны сан бүхий газрын хамгаалалтын хилийн зааг 3.8%
- Цөмийн энергийн талбай 2.6%
- Эдэлбэр газар 0.6%-ийг тус тус эзэлж байна.

Зарим орны ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох боломжгүй газар нутгийн эзлэх хувийг авч үзвэл Оросын Холбооны Улс-13.5%, Бүгд Найрамдах Казахстан Улс-8.2%, Бүгд Найрамдах Армени Улс-12.9%, Гүрж Улс-9.6%, Украин Улс-8.1%, Австрали Улс – 19.7%, Канад Улс – 12.1%, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс – 44.5%, Чили Улс – 21%, Бүгд Найрамдах Беларусь Улсад 9%-ийг эзэлж байна. Ангиллаар нь авч үзвэл дархан цаазат газар, үндэсний цогцолборт газарт, байгалийн цогцолборт газар, улсын нөөц газар, байгалийн дурсгалт газар, цэцэрлэгт хүрээлэн зэрэг багтаж байна.

Ийнхүү адил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр хувиар салбарын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан талбай тогтоосон нь салбарын хөгжлийг илт хумьж, улсын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх үр дагавартай юм.

Ашигт малтмалын тухай хуулиар дээрх байдлаар хориглосон, хязгаарласан талбайнуудыг нэр дурдаж заагаагүй боловч бусад хуулиудаар улсын тусгай хэрэгцээнд авсан газруудад хязгаарлах, хориглох асуудал зохицуулагдаж ирсэн нь хууль хоорондын зөрчил, давхардал, хийдэл ихээр үүсгэж байна.

Иймд хуулийн төслөөр улсын тусгай хамгаалалттай газар, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар, байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, онцгой хамгаалалтын бүс гэсэн 6 төрлийн газарт ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглох, зам, шугам сүлжээний газар, ойн сан бүхий газар, улсын хилийн зурвас газар, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс гэсэн 4 төрлийн газарт тусгай горимоор явуулж болохоор тусгана.

Мөн дээрх газрын төрлийг зөвхөн Ашигт малтмалын тухай хуулиар тогтоохоор зааж, бусад салбарын хуулиар улсын тусгай хэрэгцээнд авсан нэрийдлээр ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглох газрыг нэмэхгүй байх зарчмыг баримтална.

#### 1.2.7.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай:

Орон нутгийн хөгжилд чиглэсэн бүтээн байгуулалтыг дэмжих зорилгоор Ашигт малтмалын тухай хуулийн зарим нөхцөл шаардлагыг хялбаршуулан хөнгөвчилсэн зохицуулалт бүхий Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг 2015 онд баталсан.

Хууль хэрэгжсэн хугацаанд нийт 127,652.5 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын 722 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон боловч ашиглалтын тусгай зөвшөөрөл болж олборлолтын үйл ажиллагаанд шилжсэн хувь туйлын хангалтгүй бага байна. Мөн түгээмэл тархацтайгаас бусад төрлийн ашигт малтмалын илрэл бүхий талбайтай давхцуулан олгосон, төвлөрсөн суурьшлын бүсээс алслагдсан, дэд бүтэц хөгжих төлөвгүй бүсэд олгосон зэрэг нь хуулийн үндсэн зорилгоос хазайж бусад төрлийн ашигт малтмалыг түгээмэл тархацтай ашигт малтмалын нэрийн дор олборлох шинжийг агуулж эхэллээ. Хууль, шүүхийн байгууллагад шалгагдаж буй энэ төрлийн хэргийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа байдал нь үүнийг илтгэж байна.

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийн судалгаагаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь Ашигт малтмалын тухай хуультай 212 заалтаар агуулгын хувьд давхцалтай, 17 заалтын зөрчилтэй, 11 төрлийн зохицуулалтын хийдэлтэй байгаа нь тогтоогдсон.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болгож, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахтай холбоотой холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана. Ингэхдээ хөгжлийн төсөл, хөтөлбөрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газрын баталсан журмаар зохицуулах, нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмалыг ахуйн хэрэгцээнд тусгай зөвшөөрөлгүй ашиглах, дээрхээс бусад тохиолдолд түгээмэл тархацтай ашигт малтмалыг энгийн ашигт малтмалын нэгэн адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах зарчмыг тусгана.

#### 1.2.8.Бичил үүрхайн талаар:

Ашигт малтмалын тухай хуулиар тогтоосон журмыг үл хайхран өнөөдрийн амьдралын шалтгааныг түрүү барьж, гагцхүү тусгай зөвшөөрлийн үндсэн дээр, тусгай

горимоор хийгдэх ёстой “ашигт малтмал олборлох” ажлыг хууль бусаар хийх явдал нийгэмд газар авсан бөгөөд хууль зүйн хувьд нарийн зохицуулалт шаардсан асуудал болоод байна.

2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газраас баталсан журмын хүрээнд үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд нөхөрлөл, хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэд бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна.

Өөрөөр хэлбэл эзэнгүй орхигдсон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, тухайн сум орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад тодорхой хугацааны дараагаар бичил уурхай эрхлэгчийг өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх шинэ ажлын байртай болгох, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор бичил уурхай эрхлэх үйл ажиллагааг журамлаж нийт 262 талбайн дүгнэлт гаргасан нь эдгээр зорилтуудаас гажиж, гагцхүү бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх замаар хөрөнгөжих зорилго бүхий иргэд, нөхөрлөл, хоршоодын тоог нэмэгдүүлж, эвдрэлд өртөөгүй болон нөхөн сэргээлт хийгдсэн газруудыг хөндөх зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгосоор байна.

Дээрх нөхцөл шаардлагын хүрээнд бичил уурхайтай холбоотой журмаар зохицуулагдаж байсан уг харилцааг хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрлийн нийтлэг зохицуулалтад шилжүүлэх шаардлагатай байна.

#### 1.2.9. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар:

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, ашигт малтмал экспортолсон этгээд, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан этгээд байх, ашигт малтмал экспортлогч этгээд нь олон улсын зах зээлийн үнээр борлуулах, Засгийн газраас баталсан биржийн болон зах зээлийн үнийн эх сурвалжид үндэслэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах зэрэг одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээнэ. Харин технологийн хувьд ялган ашигладаг эдийн засгийн үр ашигтай дагалдах элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах зэрэг өнөөгийн практикт асуудал хүндрэл бэрхшээл дагуулдаг асуудлуудыг олон улсын жишгийг харгалзан боловсронгуй болгоно.

Ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч тооцогддог ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэлт хувь хэмжээг баталснаас хойших хугацаанд дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэд өөрчлөлт орж, зарим ашигт малтмалын нэр төрлийн үнэ тухайн үеэс нэмэгдээд байна. Үүнтэй холбогдуулан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нэмэлт хувь ногдуулах харилцааг боловсронгуй болгоно.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр "Алсын хараа-2050", зэрэг Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ашигт малтмалын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх тухай тусгагдсан. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хуулийн төсөлд

ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн боловсруулалтын түвшингээс хамаарч нэмэгдэх хувь хэмжээг боловсронгуй болгоно.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах, хувийг тооцох, тайлагнах, төлөх харилцааг хуульд нарийвчлан зохицуулж тусгана.

#### 1.2.10. Уурхай, үйлдвэрийн хаалтын талаар:

Уул уурхайн салбарт хувийн хэвшлийн оролцоо нээлттэй болсон сүүлийн 30-аад жилийн хугацаанд нөхөн сэргээлт, хаалтын эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тунхгийн шинжтэй, ёс төдий хэв шинжийг агуулсан цөөн тооны зохицуулалттайгаас эзэнгүй орхигдсон эвдэрсэн газрын хэмжээ 8 мянган га талбайд хүрч, хариуцлагагүй уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдлыг төрүүлэх болсон ба ард иргэдийн эрх ашиг, байгаль орчноо хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудын уул уурхайг эсэргүүцэх үйлдлүүд удаа дараа гарах болсон.

Хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх зорилтын хүрээнд уурхай болон баяжуулах үйлдвэрийн хаалтын эрх зүйн зохицуулалтыг тусгаж, уг харилцааг боловсронгуй болгоно. Ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгоход хаалтын урьдчилсан төлөвлөгөөг техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан боловсруулсан байхыг шаардах бөгөөд олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааны туршид хаалтын төлөвлөлтийг бодит нөхцөл байдалд нийцүүлэн тодорхой давтамжтайгаар тодотгож байхаар зохицуулна.

Зарчмын хувьд явцын нөхөн сэргээлтийг дэмжих ба хаалтын санхүүжилтийг бүрдүүлэх тооцооллыг суурь хуваарь болон гүйцэтгэсэн нөхөн сэргээлт, олборлосон ашигт малтмалын хэмжээнд үндэслэн тооцож, жил бүрийн уулын ажлын болон баяжуулалтын тайлангийн хамт тайлагнах горимыг нэвтрүүлнэ. Мөн дутуу бүрдүүлсэн хаалтын санхүүжилтийн дүнгийн хэмжээгээр системийн нөлөө бүхий арилжааны банкнаас санхүүгийн баталгаа гаргуулахыг шаардах ба уг баталгааг хаалтын тайланд үндэслэн чөлөөлөх зарчим баримтална.

#### 1.2.11. Салбар дахь орон нутгийн харилцаа, олон нийтийн оролцооны талаар:

Геологи, уул уурхайн салбарын талаарх бүх шатны нутгийн захиргааны байгууллага болон нутгийн өөрийн удирдах ёсны байгууллагуудын эрх үүрэг давхардалтай эсхүл тодорхойгүйгээс, мөн олон хууль, эрх зүйн актуудад харилцан адилгүй зохицуулалттайгаас үүдэн салбарт оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх, төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтнуудын эс үйлдэхүй түгээмэл гарах болсны дээр зохион байгуулалттай эсэргүүцлийн ажиллагаанууд газар авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зогсоох, энэ нь цаашлаад улс орон нутгийн төсвийн орлогыг тасалдуулах хүртэл сөрөг нөлөөг үзүүлэх болсон.

Иймд салбарын харилцаан дахь нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо, чиг үүрэгтэй холбоотой дараах өөрчлөлтүүдийг хуульд тодорхой тусгах шаардлага үүсэж байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй, салбарын талаарх нутгийн захиргааны байгууллага, иргэдийн ойлголтын зөрүү их, мэдээллийн дутмаг байдлаас үүдэн орон нутагт хууль бусаар үйл ажиллагаа эрхлэх,

хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжийг хаах зэрэг сөрөг үр дагавар гарч байгаа тул салбарын асуудал хариуцсан нэгжийг орон нутагт байгуулан ажиллуулах;

- Хайгуулын үйл ажиллагааны үед “байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчны хяналтын алба, сум, дүүргийн Засаг даргатай хамтран боловсруулж, Засаг даргаар батлуулдаг” үүрэгтэй байсныг өөрчилж, баталсан төлөвлөгөөгөө хүргүүлдэг болох;

- Эрлийн үйл ажиллагааны үед орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулахыг шаардахгүй. Харин тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулахдаа орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах;

- Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн дагуу явуулж байгаа аливаа үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулах, эс үйлдэхүй гаргахыг хуулиар хориглож, саад учруулсан болон эс үйлдэхүй гаргасан албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах зэрэг болно.

#### 1.2.12.Бусад:

Цөмийн энергийн тухай болон Газрын тосны тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарах энгийн буюу уламжлалт аргаар уурхайлан олборлох боломжтой ашигт малтмалын ордууд хуулиудын хоорондын зөрчлөөс үүдэн эдийн засгийн эргэлтэд орохгүй, хөрөнгө оруулалт үр өгөөж нь тодорхойгүй хугацаагаар хойшилсоор байгаа тул тус харилцааг нарийвчилж, одоогийн хуулийн хүрээнд зохицуулдаггүй шатдаг занарыг уурхайгаар олборлох, “Цөмийн энергийн талбай” гэх 4.51 сая гектар талбайд ердийн ашигт матмал хайх, ашиглах боломжийг нээх, ураны “шар нунтаг” гаргах хүртэлх олборлолтын үйл ажиллагаа зэрэг харилцаануудыг хуулийн төсөлд нэмж тусгана.

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээ 2015 оноос хойш өөрчлөгдөөгүй байгааг өнөөгийн үнэ цэнэ, ханшийн өөрчлөлттэй уялдуулан өөрчлөх шаардлагатай байна. Эдгээр төлбөрийн хэмжээ бага байх нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулалгүй удаан хугацаанд зөвшөөрлийг хадгалах нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай эдийн засгийн эргэлтэд орохгүй үндсэн зорилгоосоо хазайж, худалдах, барьцаалах, түрээслэх зэрэг санхүүгийн хэрэгслийн шинжийг агуулах болж үүнийг дагаад залилах төрлийн гэмт хэргийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа тул тусгай зөвшөөрлийн төлбөр болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тодорхой түвшинд нэмэх, тусгай зөвшөөрлийг барьцаалах зорилго, журмыг нарийвчлах зарчмыг баримтална.

Уул уурхайн салбарт төрийн бодлого гаргахад чиглэсэн суурь судалгаа хангалтгүйгээс аливаа шийдвэр нь ирээдүйд салбарын аж ахуйн нэгжүүд болон хөрөнгө оруулагчдад үзүүлэх нөлөөлөл, аливаа үр дагаврыг урьдчилан тодорхойлох боломжгүй байдал үүсгэж, улмаар уурхайнуудын ашигт ажиллагааны болон аюулгүй ажиллагааны түвшинг бууруулах эрсдэлийг үүсгэж байгаа нөхцөл байдал нь салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох уураг тархи болсон төрийн судалгааны байгууллага байх хэрэгцээ шаардлага үүссэнийг харуулж байна.

Улс орны нийт баялгийн нөөцийг хэтийн төлөвтэй уялдуулан зөв зохистой төлөвлөн удирдалгүй төсвийн зарлагыг нөхөх, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн хэрэгсэл болгон харж, гагцхүү өнөөдөр өндөр үр шим хүртэх гэсэн явцуу эрх ашгийн үүднээс ирээдүйн эдийн засгийн эргэлтэд орох боломжтой баялгийн нөөцийг үнэгүйдүүлж, цаашид урт хугацаанд тогтвортой ашиглах боломжгүй болгон орхих нөхцөл бүрдэж, уурхайнуудын насжилтыг багасгах сөрөг үр дагавар гарч байгаа тул салбарын стратеги төлөвлөлт, нөөцийн менежмент, эдийн засгийн загварчлалыг цогцоор нь уялдуулан боловсруулах институцитай байх нь чухал юм.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх зорилтын хүрээнд салбарын яамнаас төрийн бус байгууллагуудад шилжүүлсэн үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй, тэдэнд олгогдсон эрх нь өөрсдийнх нь санхүүжилтийн гол эх үүсвэр болон ашиглагдах болж, ижил зорилгыг агуулсан төрийн бус байгууллага олноор бий болж өөр хоорондоо эрх мэдлийг булаалдах байдал газар авч байна.

Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг мэргэшүүлэх болон давтан сургалтуудыг салбарын бус эсхүл мэргэжлийн бус байгууллагууд явуулж ирснээс үүдэн гарах технологийн алдаатай, мэргэжлийн бус шийдлүүдээс үүдэлтэй хор уршиг нь уурхайнуудын үйл ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрээр хохирол учруулж байгаа тул мэргэжлийн сургалт, судалгааны байгууллагын бүтцийг бий болгох зайлшгүй шаардлага байгаа болохыг гэрчилж байна.

Түүнчлэн, Засгийн газраас боловсруулж буй Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлалыг холбогдох Засгийн газрын гишүүд хамтран баталсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийн үндсэн зарчмыг тусгах замаар дээрх хуулийн төслүүдийн уялдаа холбоог нэмэгдүүлж, уул уурхай, олборлох салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх бодлогыг баримтална.

Эдгээр шаардлагын хүрээнд уул уурхайн судалгаа, хөгжлийн төвтэй байхаар хуульд тусгана.

### **Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь геологи, уул уурхайн салбарын тогтолцоо, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагаа, түүний зарчим, тусгай зөвшөөрлийн зохицуулалт, уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагааны хамрах хүрээг тогтоох, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан-техник эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл, ашигт малтмалын ордын үнэлгээ болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, геологи, уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна.

Хуулийн төсөл нь 18 бүлэг, 77 зүйлтэй байна.

Нэгдүгээр бүлэгт (Нийтлэг үндэслэл): хуулийн зорилго, ашигт малтмалын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны зарчим, ашигт малтмалын өмчлөл, тусгай зөвшөөрлийн төрөл, ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулахыг хориглосон, хязгаарласан газар, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах ерөнхий шаардлага, геологи, уул уурхайн салбарын багц дүрэм зэргийг тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт (Эрлийн үйл ажиллагаа): эрлийн үйл ажиллагаа, эрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг зохицуулалттай холбоотой харилцааг тусгана.

Гуравдугаар бүлэгт (Хайгуулын үйл ажиллагаа): хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд тавигдах шаардлага, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, хайгуулын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах, хайгуулын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт (Ашиглалтын үйл ажиллагаа): ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тавигдах шаардлага, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, ашиглалтын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх, ашиглалтын үеийн хайгуулын үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгана.

Тавдугаар бүлэгт (Баяжуулалтын үйл ажиллагаа): баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын тусгай зөвшөөрөл дуусгавар болох, хүчингүй болгох, цуцлах, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх, хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэгт (Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах): тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Долоодугаар бүлэгт (Уурхай, уулын үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа): хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлт, хаалтын үйл ажиллагааны санхүүжилтийг бүрдүүлэх, хаалтын үйл ажиллагааны хэрэгжилт, тайлагнал, хаалтын дараах хяналт шинжилгээ, арчилгаа, тордолтын талаарх зохицуулалтыг тусгана.

Наймдугаар бүлэгт (Чухал ашигт малтмал): чухал ашигт малтмалд тавигдах шаардлага, чухал ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны онцлог зохицуулалт зэргийг нарийвчлан тусгана.

Есдүгээр бүлэгт (Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл): хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл зохиоход тавигдах шаардлагыг тусгана.

Аравдугаар бүлэгт (Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр): ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр, түүний хувийг тооцох, төлөх, тайлагнах харилцааг нарийвчлан тусгана.

Арван нэгдүгээр бүлэгт (Байгаль орчныг хамгаалах): байгаль орчныг хамгаалах үүрэг, эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны байгаль орчны талаарх зохицуулалтыг тусгана.

Арван хоёрдугаар бүлэгт (Орон нутгийн харилцаа): улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажил, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны үед орон нутагтай харилцах, олон нийтийн оролцоо, байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн талаарх зохицуулалтыг тусгана.

Арван гуравдугаар бүлэгт (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, технологийн аудит): хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага, технологийн аудитын талаарх зохицуулалтыг тусгана.

Арван дөрөвдүгээр бүлэгт (Төлөвлөгөө, тайлан мэдээ): төлөвлөгөө, тайлангийн нийтлэг зохицуулалт, геологийн судалгаа, эрлийн ажлын тайлан, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангийн талаарх зохицуулалтыг тусгана.

Арван тавдугаар бүлэгт (Геологи, уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт): Улсын Их Хурал, Засгийн газар, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх хэмжээ, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээ, геологи, уул уурхайн асуудал хариуцсан орон нутаг дахь нэгж, геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Уул уурхайн судалгаа, хөгжлийн төвийн талаарх зохицуулалтыг тусгана.

Арван зургаадугаар бүлэгт (Мэдээллийн сан): мэдээллийн сангийн хэлбэр, мэдээллийн сангийн төрөл, бүрдэл, мэдээллийн сан хөтлөх, бүрдүүлэх үйл ажиллагааны зохицуулалтыг тусгана.

Арвандолоодугаар бүлэгт (Уул уурхайн үйлдвэрлэлийн санхүү, бүртгэлийн онцлог, нөхөн төлбөр): уул уурхайн үйлдвэрлэлийн санхүү бүртгэлийн онцлог, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологи, хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн талаарх зохицуулалтыг тусгана.

Арван наймдугаар бүлэгт (Хариуцлага, бусад): хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа, байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлт, уурхай, үйлдвэрийн хаалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, орон нутгийн уялдаа холбоо, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг хамарсан эрх зүйн шинэлэг зохицуулалтыг бий болгоно.

Эрлийн үйл ажиллагааг хувийн хөрөнгөөр гүйцэтгэх боломжийг бүрдүүлж, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох зохицуулалтыг хуульчилж, чухал ашигт

малтмалын тухай ойлголтыг тусган, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газрын төрлийг нарийвчилж, цаашид нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталснаар хайгуулын чиглэлд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалт тодорхой түвшинд нэмэгдэж, шинэ ордууд нээгдэх боломжийг өсгөнө.

Тусгай зөвшөөрлийг цуцлах, хүчингүй болгох үндэслэлийг цөөлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн харилцааг оновчилж, салбарын үйл ажиллагаа дахь байгаль орчин, орон нутгийн харилцаа, иргэд, олон нийтийн оролцооны зохицуулалтыг боловсронгуй болгож, эдгээр үйл ажиллагаан дахь хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаснаар салбарт хөрөнгө оруулагчдын идэвх, итгэлийг нэмэгдүүлж, уул уурхайн төслүүд амжилттай хэрэгжих боломж бүрдэж, цаашлаад салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж экспорт нэмэгдэж, валютын нөөц, улсын эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө.

Салбарын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчилж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагыг нарийвчилж, тусгай зөвшөөрлийн төлбөр, хүчинтэй хугацааг уялдуулан шинэчилж, газрын хэвлийн баялгийг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр, үйлдвэрлэлийн аргаар ашиглах зарчмыг баримталж, уурхай, үйлдвэрийн хаалтын шинэ тогтолцоог санхүүгийн баталгааны механизмтай уялдуулан бий болгосноор хариуцлагатай уул уурхайн тогтолцоо улам бэхэжнэ. Ингэснээр салбарын талаарх олон нийтийн ойлголт, итгэл нэмэгдэж, эсэргүүцэл багасна.

Салбар дахь орон нутгийн харилцаа, олон нийтийн оролцооны талаар хуульд тусгайлан зохицуулснаар нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийт болон хөрөнгө оруулагчдын хоорондын харилцан ойлголцол сайжирна.

Геологи, уул уурхайн салбарын мэдээллийн сангийн зохицуулалтыг хуульчилснаар төрийн болон нутгийн захиргааны байгууллага, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, аж ахуйн нэгжүүдийн үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, хяналтын тогтолцоо тодорхой болж, нээлттэй, ил тод орчин бүрдэнэ.

Хуульд заасан нэр томъёоны зохицуулалт илүү тодорхой, ойлгомжтой болж, хууль хоорондын уялдаа холбоо сайжирч, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилна.

**Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүйд тооцох хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хуультай нийцсэн байна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хүчингүй болсонд тооцох тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай, Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Барилгын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тосны тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Гол нэр төрлийн зарим

бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Зөвшөөрлийн тухай, Зөрчлийн тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Ойн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Тусгай хамгаалалттай орчны бүсийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Усны тухай, Цөмийн энергийн тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай, Эрүүгийн хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон шаардлагатай холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

-----oOo-----